



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/247

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчигээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын А заалт буюу А-1-д "Гэмтэл согог судлалын үндэсний төв"-ийн MRI аппаратын хөргөлтийн гель цэнэглэх болон аппаратын дагалдах засварт 176,000,000 /Нэг зуун далан зургаан сая/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Гэмтэл согог судлалын үндэсний төв /Б.Бат-оргил/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан хуулийн дагуу зохион байгуулахыг Гэмтэл согог судлалын үндэсний төв /Б.Бат-оргил/-д, ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Энхболд/-т тус тус даалгасугай.

САЙЛ



С.ЛАМБАА

080904